



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/329

Булган сум

Төрийн байгууллагуудын ажлын
цагийн хуваарьт зохицуулалт хийх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.2, 94 дүгээр зүйлийн 94.1, 94.2, 94.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн албан хаагчдын ажил, амралтын цагийг зохицуулах зорилгоор 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс 08 дугаар сарын 31-ний өдрийг дуустал аймгийн хэмжээнд төрийн байгууллагын ажлын цагийг 08:00 цагаас 17:00 цаг, амрах, хооллох завсарлагыг 12:00 цагаас 13:00 цагийн хооронд байхаар тогтоосугай.

2.Захирамжийг иргэд, олон нийтэд мэдээлж, хэрэгжилтийг хангаж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр), сумын Засаг дарга, байгууллагын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР